



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
М.ЭНХ-АМАР ТАНАА

2020.02.21 № 06/591
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Ц. Чингэлтэй
Амгалант
(Сангийн төлөөлөгч)
Бэлсүр
2020/02/21

Аудитын гол асуудал

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь "Хязгаарлалттай санал дүгнэлт" өгөх үндэслэл болно. Үүнд:

- Төсвийн зориулалтыг өөрчлөн урсгал зардлаас 119,500.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
- Өмнөх оны санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдлээр тусгагдаагүй 2018 онд 3 иргэн, 16 төрийн бус байгууллагатай байгуулсан гэрээт ажлын үлдэгдэл 120,134.1 мянган төгрөгийн төлбөрийг төлж, санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- 2017 оноос байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа худалдан авалт, хөгжүүлэлт, сайжруулалтын нийт 116,862.5 мянган төгрөгийн өөрийн өртөгтэй "Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн нэгдсэн сан"-гийн программыг хөрөнгийн орлогоор бүртгээгүй;
- Бараа материалын 64,307.8 мянган төгрөгийн үлдэгдэлд жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгээгүй;
- Бусад үндсэн хөрөнгийн дансанд 75,008.7 мянган төгрөгийн барилга, байгууламжийг данс буруу ангилж бүртгэсэн;

зэрэг нь Үнэн зөв байдал, Оршин байх, Иж бүрэн байх, Тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 02

№ 01/38

Улаанбаатар хот

СМГ-2020/174/СТА-ТЧЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төсвийн зориулалтыг өөрчлөн урсгал зардлаас 119,500.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай тус тус хэрэгжүүлж ажиллах" заасныг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах, дотоод хяналт, дотоод аудитыг сайжруулах арга хэмжээ авч биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга М.Энх-Амар, ахлах нягтлан бодогч У.Батнасан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР С.БАТ-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
М.ЭНХ-АМАР
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ
У.БАТНАСАН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.


**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6-7
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал	11-14
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16-17
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18-19
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21-22
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	23
Хавсралт	
5.1 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	24-25
Албан шаардлага	
6.1 Албан шаардлага.....	26



1.Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.24 № 06/591
танай _____ -ны № _____ -т

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
М.ЭНХ-АМАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



\\10.10.10.20\Bichig_KheregiYawsan_Bichig\2020\0221SAG33.Docx

0105073

Аудитын гол асуудал

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь "Хязгаарлалттай санал дүгнэлт" өгөх үндэслэл болно. Үүнд:

- Төсвийн зориулалтыг өөрчлөн урсгал зардлаас 119,500.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
- Өмнөх оны санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдлээр тусгагдаагүй 2018 онд 3 иргэн, 16 төрийн бус байгууллагатай байгуулсан гэрээт ажлын үлдэгдэл 120,134.1 мянган төгрөгийн төлбөрийг төлж, санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- 2017 оноос байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа худалдан авалт, хөгжүүлэлт, сайжруулалтын нийт 116,862.5 мянган төгрөгийн өөрийн өртөгтэй "Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн нэгдсэн сан"-гийн программыг хөрөнгийн орлогоор бүртгээгүй;
- Бараа материалын 64,307.8 мянган төгрөгийн үлдэгдэлд жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгээгүй;
- Бусад үндсэн хөрөнгийн дансанд 75,008.7 мянган төгрөгийн барилга, байгууламжийг данс буруу ангилж бүртгэсэн;

зэрэг нь Үнэн зөв байдал, Оршин байх, Иж бүрэн байх, Тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.



Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.Аудитын тайлан

2.1. Оршил

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга М.Энх-Амар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох Шүүхийн шийдвэрээр нөхөн олгосон цалингийн зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, санхүүгийн тайланд өр төлбөрийг үнэн зөв тайлагнаж байх, бүртгэлгүй байгаа биет бус хөрөнгийг орлого авах, эд хөрөнгийн тооллогын үнэн зөв гүйцэтгэж байх, барилга байгууламжийг зөв дансанд ангилж бүртгэх, бараа материал дансны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Бат-Эрдэнэ хариуцаж хэрэгжүүлэв.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/128 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Төрийн бодлогыг гэр бүлд суурилан хэрэгжүүлэх эрх зүй, тогтолцооны шинэчлэлд үнэт хувь нэмэр оруулж, гэр бүл, хүүхэд, залуучуудыг хамгаалах, хөгжүүлэх, төлөвшүүлэх үйлчилгээг сайжруулах замаар Монгол хүний хөгжил, үндэсний дархлааг бэхжүүлэхэд оршино" гэж тодорхойлсон байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суурь судалгаанд үндэслэсэн гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулах, гэр бүлийн хөгжлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх;
- Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаарх төрийн бодлого, хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нийгмийн үйлчилгээг үзүүлэхэд салбар дундын зохицуулалтыг хангах, орон нутгийн нэгж, харьяа байгууллагад арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Залуучуудын хөгжил, оролцоо, манлайллыг дэмжсэн нийгмийн орчныг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн сурталчилгаа, нөлөөлөл, хамтын ажиллагаа, түншлэлийн хангах;
- Үйл ажиллагааны төлөвлөлт, үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог төлөвшүүлж, статистик тоон үзүүлэлт бүхий гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянах, мэдээллийн сангийн үйл ажиллагааны менежментийг сайжруулах;
- Удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, ил тод байдлыг хангаж ажиллах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн

үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 7,922,169.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 79,221.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь сонгосон суурь үзүүлэлтээс буюу санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,466,951.3 мянган төгрөгийн 1 хувь буюу 64,669.5 мянган төгрөгөөр тооцлоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 586,643.0 мянган төгрөгөөр буюу 40.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	70,151.86	157,550.61	87,398.76
Урьдчилгаа	0.00	269,220.00	269,220.00
Бараа материал	15,594.86	66,043.05	50,448.19
Үндсэн хөрөнгө	1,397,564.49	1,577,140.55	179,576.06
Нийт хөрөнгө	1,483,311.21	2,069,954.21	586,643.00
Өр төлбөр	0.00	3,439.50	3,439.50
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,483,311.21	2,066,514.71	583,203.50
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,483,311.21	2,069,954.21	586,643.00

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл болон урсгал төсвийн дансны нэр данс зөрүү орлогын үлдэгдлийг төвлөрүүлснийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэснээс шалтгаалсан байна. Татаас санхүүжилтийн 156,350.6 мянган төгрөгийн, байгууллагаас авах 1,200.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Урьдчилгаа дансанд "Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гэр бүл, эцэг эхчүүдэд зориулсан бүрэн хэмжээний уран сайхны кино хийх" зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчид 266,300.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлсэн,

автомашины дулаан зогсоолын түрээсийн урьдчилж төлсөн 2,920.0 мянган төгрөгийн зардлыг тус тус бүртгэсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 622,059.9 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй 780.7 мянган төгрөгийн бараа материалын орлого авч, 572,392.3 мянган төгрөгийн зарцуулалт хийж, 66,043.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Нийт бараа материал дансны үлдэгдлийн 1.8 хувийг бичиг хэргийн материал, 5.2 хувийг аж ахуйн материал, 0.8 хувийг түлш, шатах тослох материал, 1.7 хувийг хүнсний материал, 90.5 хувийг бусад хангамжийн материал тус тус эзэлж байна. Бусад хангамжийн материалын данс их хэмжээний үлдэгдэлтэй байгаа нь жилийн эцэст хэвлүүлсэн ном, гарын авлага, тараах материалын зарцуулагдаагүй үлдэгдэл ихэнх хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгө данс оны эхэнд 1,397,564.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол төсвийн хөрөнгөөр 195,598.9 мянган төгрөгийн, хандив тусламжаар 79,536.4 мянган төгрөгийн, балансаас баланс хооронд 11,262.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй зэрэг нийт 286,397.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн орлого бүртгэж, 106,821.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг хасагдуулж, жилийн эцсийн байдлаар 1,577,140.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн цэвэр үлдэгдэлтэй байна.

Өр төлбөр дансанд 3,439.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь бараа, ажил үйлчилгээний төлбөрийг шилжүүлсэн боловч нэр данс зөрж буцсан гүйлгээг төсвийн жилд багтаан залруулаагүйгээс байгууллагад төлөх өглөг үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,066,514.7 мянган төгрөг болж 586,643.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн санхүүгийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 6,457,482.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж, урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Улсын төсвөөс 6,457,482.3 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,389,677.0 мянган төгрөг буюу 98.9 хувьтай ба зарцуулагдаагүй үлдэгдэл 67,805.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлын гүйцэтгэлийг бүлгийн дүнгээр авч үзвэл цалингийн зардал 11,721.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 18,281.6 мянган төгрөгөөр, нормативын зардал 7,860.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 7,239.8 мянган төгрөгөөр, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 21,700.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 1,002.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна. Шалтгаан нөхцөлийг тодруулбал:

- Цалингийн зардал зардал хүүхдийн тусламжийн 108 утасны төвийн цалингийн зардал гүйцэтгэлээрээ дутуу зарцуулагдсан;
- Байр ашиглалттай холбоотой зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлууд нь бодит гүйцэтгэлээрээ дутуу зарцуулагдсан;
- Нормативын зардлаас нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардал дээр түр хамгаалах байранд дуудлагаар ирсэн хүүхдүүдэд шаардлагатай үед хувцас авч өгөхөөр төсөвлөсөн зардал гүйцэтгэлээрээ дутуу;

- Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал хэмнэгдсэн нь салбарын ажилтнуудыг гадаад, дотоодын туршлага судлуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн ажил хийгдээгүйгээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: НҮБ-ийн Хүүхдийн сан, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 409,172.7 мянга, Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төслөөс 80,670.4 мянга, өмнөх оны татаас санхүүжилтийн авлагын үлдэгдлээс 30,151.8 мянга, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 11,690.0 мянга нийт 531,864.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс гадаад, дотоод албан томилолтын зардалд 9,625.6 мянган төгрөгийг, бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 356,258.2 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 165,801.1 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,045,406.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,532,041.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 119,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 393,865.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Аудитаар ажил, гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэсэн 1,183,822.2 мянган төгрөгийн, 269,220.0 урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй, тайлант жилд ногдох түрээсийн зардлыг 2,920.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн, 14,050.0 мянган төгрөгийн худалдан авсан хөрөнгө, бараа материалыг орлогоор бүртгээгүй, хүүхэд хөгжил, хамгааллын зардлаас гүйцэтгүүлсэн 2 төсөл, арга хэмжээний 62,029.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авсан боловч хөрөнгийн орлогоор бүртгээгүй зэрэг нийт 1,532,041.3 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулгыг хийлгэв.

2. Төсвийн зориулалтыг өөрчлөн урсгал зардлаас 119,500.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 393,865.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн шатны аудитаар авч үзэх болон анхаарал татахуйц дараах асуудлууд байна. Үүнд:

- ХНХС-ын 2019 оны 2019 оны А/181, А/186 дугаар тушаалаар Нийслэл, дүүргийн ГБХЗХГ-ын Хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаанд зарцуулах 2,000.0 сая төгрөгийн төсвийг ГБХЗХГ-ын бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын эдийн засгийн ангилал дээр баталж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг тус газрын даргад үүрэг болгосон ба Төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дээрх арга хэмжээг тусгаагүй байна. ХНХС-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу ГБХЗХГ-ын даргын 2019 оны А/58 дугаар тушаалаар Нийслэл, дүүрэгт 1,990.0 сая төгрөгийн, Өвөрхангай аймгийн ГБХЗХГ-т 28.0 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу шилжүүлсэн боловч, зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.

- Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь цаг хугацааны хувьд төсвийн жилд хэрэгжих боломжгүй байхад "Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гэр бүл, эцэг эхчүүдэд зориулсан бүрэн хэмжээний уран сайхны кино хийх" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, төсөл, арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэх 300,000.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 274/2019 дугаартай гэрээг байгуулан 266,300.0 мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг шилжүүлсэн;

- Байгууллагын даргын хотын доторх албан ажлын хэрэгцээнд 4608 см3 хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж бүхий Toyota Land cruiser 200 маркийн автомашин хэрэглэж байгаа;

- ГБХЗХГ-ын даргын 2019 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн А/211 дугаар тушаалаар Дорнод аймаг дахь "Анна хоме асрамж, халамжийн төв"-ийн барилга гал түймэрт өртсөнтэй холбоотойгоор 77,000.0 мянган төгрөгийн дэмжлэгийг урсгал үйл ажиллагааны төсвөөс олгосон асуудлууд байна.

Дээрх асуудлыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын түвшинд хийх аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

ГБХЗХГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 83 мэдээллийг хугацаанд нь, 56 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 587,394.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Эргэлтийн хөрөнгийн тооллогыг цаг хугацаанд нь чанартай үнэн зөв гүйцэтгэж, холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах гэсэн 1 зөвлөмжийг өгсөн боловч дээрх алдаа зөрчлийг давтан гаргаж, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл


Бид ГБХЗХГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 513,365.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 64,669.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай санал дүгнэлтийг өгч байна.

ГБХЗХГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хоёр ажилтанд ажлаас чөлөөлөгдсөн хугацааны нийт 17,552.0 мянган төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгосон боловч буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Өр төлбөртэй холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

